

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

ТАНЫ АНХААРАЛД

Дэлхийн цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэг нь 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг. Сарын цаг агаарын урьдчилсан мэдээнд сарын дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны хэмжээг дараах дөрвөн бүс нутгаар тус бүрээр урьдчилсан мэдээлнэ.


- о **Баруун** (Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор)
- о **Төв** (Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв)
- о **Зүүн** (Хэнтий, Дорнод, Сүхбаатар)
- о **Говь** (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говь-Сүмбэр)

Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "нийт нутгаар" гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 0°-аас бага болж хүйтрэхийг "цочир хүйтрэл" гэнэ.

Сар, улирлын урьдчилсан мэдээний талаар лавлах бол Ус, Цаг Уур, Орчны Судалгаа Мэдээллийн Хүрээлэнгийн 11-326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн Цаг Агаар, Орчны Тоон Загварчлал Судалгааны Хэлтэс"–ээс тодруулах боломжтой.


Уур амьсгалын тойм

Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгий, Завхан, Хөвсгөлийн ихэнх нутаг, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төвийн зүүн хойд хэсгээр -4...-10°C хүйтэн, Өмнөговийн нутаг, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговийн өмнөд хэсгээр +8...+12°C дулаан, бусад нутгаар +6°C дулаанаас -2°C хүйтэн байдаг (**Зураг 1**).



Зураг 1. 04-р сарын агаарын температурын ОЖД, [°C].


Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Орхон–Сэлэнгийн сав, Дорнодын тал нутгаар 8–10 мм, Их нууруудын хотгор болон говийн бүсийн өмнөд хэсгээр 0–2 мм, бусад нутгаар 2–6 мм ордог байна (**Зураг 2**).



Зураг 2. 04-р сарын нийлбэр хур тунадасны ОЖД, [мм].

Агаарын дундаж температур болон хур тунадас олон жилийн явцыг зураг 3-д харуулав. Зургаас харахад 2000 оноос хойших жилүүдэд дөрөвдүгээр сарын агаарын температур ОЖД-аас харьцангуй дулаан байсан ба тухайлбал 2004–2005, 2007–2010, 2011–2012, 2014–2020 онуудад ихэнх нутгаар олон жилийн дунджаас 2–6°C-аар дулаан байсан байна. Харин 1979–1980, 1983–1986, 1988, 1990–1991, 1993, 2010 онуудад агаарын температур олон жилийн дунджаас 2–6°C-аар хүйтэн байсан байна (**Зураг 3а**).


Хур тунадасны хувьд 1979–1981, 1985, 1990, 1994–1995, 1998–2003, 2014–2016, 2018, 2021 онуудад ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас орсон бол 1982–1984, 1987–1988, 1992, 1996–1997, 2004, 2019–2020 онуудад олон жилийн дунджаас бага хур тунадас орсон байна (**Зураг 3б**).



Зураг 3а.

04-р сарын агаарын дундаж температурын олон жилийн явц

[хөх – ОЖД-аас хүйтэн, улаан – ОЖД-аас дулаан]



Зураг 36.

04-р сарын нийлбэр хур тунадасны олон жилийн явц

[шар – ОЖД-аас бага, ногоон – ОЖД-аас ахиу]

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Баруун аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД-аас дулаан байх төлөвтэй байна (Зураг 4). Хур тунадас Баян-Өлгий, Ховд, Говь-Алтайн нутаг, Увсын баруун, Баянхонгорын баруун өмнөд хэсгээр ОЖД-аас бага, бусад нутгаар дунджийн орчим байна (Зураг 5).

Агаарын температур, хур тунадасны явцыг Зураг 6-д харуулав. Сарын эхээр нутгийн хойд хэсгээр бага зэргийн хур тунадас орж, ихэнх нутгаар салхи шуургатай байх төлөвтэй байна. Цаашдаа хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн зарим үеүдэд ихэнх нутгаар хур тунадас орж, агаарын дундаж температур нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үе, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлч үеүдэд ОЖД-аас 1–3°C-аар хүйтэн байх бол нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн ихэнх хугацаанд болон гуравдугаар арав хоногийн эхээр ОЖД-аас 1–3°C-аар дулаан байх төлөвтэй байна.

Төвийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Хөвсгөлийн нутаг, Архангайн баруун, Өвөрхангай аймгийн өмнөд хэсгээр ОЖД-аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим (Зураг 4), хур тунадас ихэнх нутгаар ОЖД-ийн орчим (Зураг 5) байх төлөвтэй байна.


Агаарын температур, хур тунадасны явцыг Зураг 7-д харуулав. Сарын эхээр нутгийн хойд хэсгээр хур тунадас орж, ихэнх нутгаар салхи шуургатай байх төлөвтэй байна. Цаашдаа хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн зарим үеүдэд ихэнх нутгаар хур тунадас орж, агаарын дундаж температур нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үе, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлч үеүдэд ОЖД-аас 1–3°C-аар хүйтэн байх бол гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар ОЖД-аас 1–4°C-аар дулаан, бусад хугацаанд ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна.

Зүүн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД-ийн орчим, хур тунадас ахиу байх төлөвтэй байна (Зураг 4, 5).


Агаарын температур, хур тунадасны явцыг Зураг 8-д харуулав. Сарын эхээр ихэнх нутгаар хур тунадас орж, салхи шуургатай байх төлөвтэй байна. Цаашдаа хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлч үеүдэд хур тунадас орж, агаарын дундаж температур нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн сүүлч үеүдэд ОЖД-аас 1–3°C-аар хүйтэн байх бол гуравдугаар арав хоногийн эхээр ОЖД-аас 1–3°C-аар дулаан, бусад хугацаанд ОЖД-ийн орчим байх төлөвтэй байна.

Говийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Өмнөговийн нутаг, Дундговь, Дорноговийн өмнөд хэсгээр ОЖД–аас дулаан, бусад нутгаар ОЖД–ийн орчим байна. Хур тунадас Говьсүмбэрийн нутаг, Дорноговийн хойд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 4, 5**).


Агаарын температур, хур тунадасны явцыг **Зураг 9**–т харуулав. Сарын эхээр нутгийн хойд хэсгээр хур тунадас орж, ихэнх нутгаар салхи шуургатай байх төлөвтэй байгаа бол цаашдаа хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр ихэнх нутгаар хур тунадас орж, салхи шуургатай, хүйтэн байх төлөвтэй байна. Агаарын дундаж температур нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн сүүлээр ОЖД–аас 1–3°C–аар хүйтэн байх бол хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн эхээр ОЖД–аас 1–3°C–аар дулаан байх төлөвтэй байна.




Зураг 4. 2024 оны 04–р сарын агаарын дундаж температурын урьдчилсан мэдээ, C°
[Д – агаарын дундаж температур ОЖД–аас дулаан, Н – агаарын дундаж температур ОЖД–ийн орчим]



Зураг 5. 2024 оны 04-р сарын нийлбэр хур тунадасны урьдчилсан мэдээ, мм
 [И – хур тунадас ОЖД-аас их, Н – хур тунадас ОЖД-ийн орчим, Б – хур тунадас ОЖД – аас бага]




Зураг 6. Баруун аймгуудын нутгийн 2024 оны 04-р сарын агаарын температур, хур тунадасны явц
 [Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, **улаан** – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, **хөх** – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, **ногоон** – хур тунадасны хэмжээ]




Зураг 7. Төвийн аймгуудын нутгийн 2024 оны 04-р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, **улаан** – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, **хөх** – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, **ногоон** – хур тунадасны хэмжээ]



Зураг 8. Зүүн аймгуудын нутгийн 2024 оны 04-р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, **улаан** – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, **хөх** – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, **ногоон** – хур тунадасны хэмжээ]



Зураг 9. Говийн аймгуудын нутгийн 2024 оны 04–р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, **улаан** – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, **хөх** – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, **ногоон** – хур тунадасны хэмжээ]

ЗӨВЛӨМЖ

Дөрөвдүгээр сард ихэнх нутгаар ОЖД–аас дулаан, хур тунадас нутгийн баруун хэсгээр харьцангуй бага, харин нутгийн зүүн хэсгээр ОЖД–аас ахиу, төв болон говийн ихэнх нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна.

Сарын эхээр нутгийн хойд хэсгээр хур тунадас орж, ихэнх нутгаар салхи шуургатай, хүйтэн байх төлөвтэй байна. Цаашдаа хоёрдугаар арав хоногийн дунд үе болон гуравдугаар арав хоногийн ихэнх хугацаанд цаг агаар тогтворгүй байх төлөв ажиглагдаж байгаа тул богино хугацааны нарийвчилсан мэдээ цаг тухай бүрт авч ашиглахыг зөвлөж байна.